

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН САЛБАРЫН НЭГДСЭН
ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРДУЛАМЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1: САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ							
1.1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.							
1.	Арга хэмжээ №1.1.1 “Алсын хараа 2050” улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Тайлан -1	“Алсын хараа 2050” улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан барилга, хот байгуулалтын чиглэлийн 10 зорилт, 44 төсөл, арга хэмжээний 2024 оны төлөвлөгдсөн ажлын хэрэгжилт хяналт шинжилгээний үнэлгээгээр 86.6%	“Алсын хараа 2050” улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын тайланг боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.	ЗГХЭГ зохион байгуулсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2020-2025 оны хэрэгжилтийн нэгдсэн тайлангийн төслийн хэлэлцүүлэг, салбар хуралдаанд 2025.05.01, 2025.05.09, 2025.05.26-ны өдрүүдэд оролцсон. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5 жилийн хэрэгжилтийн нэгдсэн тайлангийн төсөлд ХББОСЯ-ны хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн боловсруулж Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн mongolia.vision2050@gmail.com, office@2050.gov.mn цахим хаягт 2025.05.15-ны өдөр хүргүүлсэн. /хугацаа болоогүй 3-р улирал/	2025.09.30	

2.	Арга хэмжээ 1.1.2 "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Тайлан -1		"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжилтийн явцын тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана.	Хугацаа болоогүй. /4-р улирал /	2025.12.30	
3.	Арга хэмжээ 1.1.3 "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Тайлангийн тоо-1		Хэрэгжилтийн явцын тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна.	Хугацаа болоогүй. /3-р улирал /	2025.09.30	
4.	Арга хэмжээ 1.1.4. "Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээний тоо	"Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг УИХ-ийн 21 дүгээр тогтоолоор баталсан.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их хурлын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар батлуулсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны зүгээс 7 зорилго 46 зорилтын 71 арга хэмжээг нэгтгэн боловсруулж тусгуулсан. Батлагдсан төлөвлөгөө болон үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг олон нийтэд 2025.04.30-ны өдөр байгууллагын дотоод сүлжээ /ERP/-д байршуулсан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын тайланг нэгтгэн боловсруулж 2025.06.10-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн.	2025.06.30	

5.	Арга хэмжээ 1.1.5. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө” боловсруулахад салбарын бодлогыг тусгуулах ажлыг зохион байгуулна.	Төлөвлөгөөнд тусгахаар хүргүүлсэн санал	“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” УИХ-ын 35 дугаар тогтоолоор батлагсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ 25	Явцын тайлан мэдээг холбогдох газарт гаргаж өгсөн байна.	ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/ тушаалаар байгуулагдсан. “МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл”-д тусгуулах салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/159, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 04/1267 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Мөн Эдийн засаг хөгжлийн яам 2025.03.10, 2025.03.20-ны өдрүүдэд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож, ХББОСЯ-ны төлөвлөгөөний төсөлд засвар өөрчлөлтийг хийж, тайлбар үндэслэлийн хамт 2025.03.26, 2025.04.18, 2025.05.08, 2025.05.13-ны өдрүүдэд тус тус цахимаар ЭЗХЯ-нд хүргүүлсэн “МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, холбогдох хавсралтуудад 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/1427 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд саналыг холбогдох тайлбарын хамт хүргүүлсэн. Монгол Улсын Их хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлагдсан.	2025.06.30	
6.	Арга хэмжээ 1.1.6 Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Ажлын хэсэг - 1, төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээний тоо		“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028” оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	ХББОСЯ-ны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/31 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нийт 4 удаа хуралдаж “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 2024-2028 онд хэрэгжүүлэх 6 зорилтын 92 арга хэмжээг тусган боловсруулсан. Яамны стратеги төлөвлөгөөг ХББОС-ын сайдын 2025.05.29-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлуулсан.	2025.06.30	

7.	Арга хэмжээ 1.1.7 Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-1 Тайлан-1		Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2025 оны эхний хагас жилд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.03.06-ны өдрийн 02 дугаартай албан даалгаврыг хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025.04.16-ны өдөр ХББОС-ын сайдаар батлуулсан. Төлөвлөгөөнд туссан 50 арга хэмжээний явцын мэдээ тайланг 2025.05.27-ны өдрийн 01/2034 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	2025.07.10	
Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
8.	Арга хэмжээ 3.1. Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана.	Саналын тоо, Оролцсон арга хэмжээний тоо	-	5	Энэ оны хагас жилийн байдлаар бусад яам, холбогдох газруудаас ирсэн хууль тогтоомж бодлогын баримт бичгүүдэд нийт 5 санал өгсөн байна. Үүнд: 1. Эдийн засаг, хөгжлийн яамны “Монгол Улсын хөгжлийн 2026” оны төлөвлөгөөнд төсөлд хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын чиглэлээр тусгуулах төсөл, арга хэмжээний 11 санал, 2. ЗГХЭГ-т Улсын Их хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл тусгуулалх сэдэв 1 санал, 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Хангайн бүсэд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд 1 санал, 4. Эдийн засаг, хөгжлийн яамны “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө” батлах тухай тогтоолын төсөл болон холбогдох хавсралтуудад 14 санал, 5. Эдийн засаг, хөгжлийн яамны “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 4 санал.	2025.01.01-2025.06.30	

9.	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.	Гүйцэтгэл	-	100%	Зөвшөөрөлгүй баригдсан барилгын зөвшөөрлийг нөхөн олгохтой талаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд утсаар болон биечлэн холбогдож асуултад хариулж, асуудлыг шийдвэрлэж ажилласан. 2021 оноос хойших байдлаар Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг, даалгаврын хэрэгжилт нь хангалтгүй, биелэгдээгүй, удааширсан төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг яамны хэмжээнд зохион байгуулж нэгтгэн бэлтгэж ХШУДАГ-ын дарга Ган-Очир даргад 2025.05.09-ны өдөр хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.30	
10.	Арга хэмжээ 3.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах.	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тоо	-	0	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчил гаргаагүй.	2025.01.01-2025.06.30	
11.	Арга хэмжээ 3.4. Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж, явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх	Албан бичиг, өргөдөл, гомдол, тоо	-	100%	Ирсэн бичиг 14, нийт 12 албан бичгийг хугацаанд хүргүүлж шийдвэрлэсэн. Хугацаа хоцорсон бичиг байхгүй.	2025.01.01-2025.06.30	
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ний биелэлт							
д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
12.	Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн нэртэй аудит хийхэд зохион байгуулж ажиллах	Аудитад шаардлага тай нотлох баримтууд	-	Аудитад шаардлагатай баримт материалыг гаргаж өгсөн байна.	Үндэсний аудитын газраас үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн нэртэй аудиторт шаардлагатай баримт материалыг нотлох баримтын хамт хавсарган шаардлагатай судалгаа, мэдээллийг бэлтгэж 2025.05.23, 28-ны өдөр хүргүүлсэн. Үүнд: Алсын хараа 2050, Үндсэн чиглэл 2021-2025, ЗГҮАХ 2020-2024, ЗГҮАХХАХТ 2020-2024, БХБЯ-ны 2020-2024 оны стратеги төлөвлөгөө, МУХ 2021-2024 зэрэг бодлогын баримт	2025.05.12-2025.06.30	


					бичгүүдийн төлөвлөлт, санал, үндэслэл, тооцоо судалгааг бүрдүүлж өгсөн.		
13.	“Дулаан байшин” - Амины орон сууцны нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулах	Гэрээ -1	-	Гэрээний хэрэгжилтийг хангуулсан байна.	“Дулаан байшин - Амины орон сууцны нээлттэй өдөрлөг”-ийн үеэр талбайн цэвэрлэгээ тохижилтын ажлыг хариуцан “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тай ажил гүйцэтгэх гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.	2025.05.04- 2025.05.07	
14.	Орон нутагт ажилласан томилолт	Томилолтын тайлан -1	-	Томилолтоор ажилласан тайланг байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан байна.	Удирдамжийн хүрээнд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан “Миний сонголт-Төрийн алба” орон нутагт зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Сайдын 2025 оны 22 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-т хамрагдсан сумдуудаар орж төрийн албан хаагчийн 15 айлын орон сууцыг барих газрын сонголт болон дулаан, ус, ариутгах татуурга, цахилгаан хангамжийн шугам сүлжээний хүртээмжийг газар дээр нь үзэж, шинжлэн судлах, мөн тухайн аймгуудын төв болон сумдад сайдын багцын хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжүүлж байгаа, 2025 онд шинээр эхлэх улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтын талаар аймгуудын Засаг дарга, ИТХ-ын дарга, сумдын Засаг дарга, удирдлагуудтай санал солилцож, холбогдох байгууллага, албан тушаалтнаас авч мэдээлэл авч, зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа. Томилолтын тайланг тайлагнаж, байгууллагын дотоод сүлжээнд 2025.02.20-ны өдөр байршуулсан.	2025.02.08- 2025.02.20	
15.	Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	Тендерийн баримт бичгийн тоо-3		Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.	“Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шатны хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Дорнод аймгийн Халхгол, Чулуунхороот, Чойбалсан, Хэнтий аймгийн Биндэр, Хэрлэн сумдад тус тус баригдах 8 болон 15 айлын орон сууцны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн	2025.02.19- 2025.06.30	

					баримт бичиг боловсруулсан тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/34 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Хэнтий аймгийн Биндэр, Хэрлэн сум, Дорнод аймгийн Чулуунхороот, Чойбалсан, Халхгол сумдын ТББ-г хэлэлцэх үнэлгээний хорооны хурлыг 2025.04.14, 2025.04.16, 2025.05.23-ны өдрүүдэд хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025.05.30-ны өдөр гэрээг байгуулсан. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумын тендерт оролцогч материал ирүүлээгүй тул дахин зарлаж 2025.05.30-ны өдөр нээсэн боловч хэмнэлтийн тухай хуулиар гэрээ байгуулах боломжгүй болсон.		
16.		Төсөл арга хэмжээний тоо -4	-	ЭЗХЯ-ны цахим системд бүртгүүлсэн байна.	Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тус яамнаас тусгуулах төслүүдийн саналыг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-нд 2025.04.28-ны 01/1267 тоот албан бичгээр хүргүүлж, төслүүдийн холбогдох мэдээллийг www.invest.gov.mn цахим бүртгүүлсэн. Үүнд: 1. Залуус -1 орон сууцны хороолол 2. Солонго 1,2 орон сууцны хороолол 3. АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй туршилтын газрын гүнийн геотермийн дулааны станц 4. Монгол, Хятад улсын ерөнхийлөгч нарын нэрэмжит “Президент” спорт цогцолбор.	2025.02.14- 2025.04.28	
Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь

1.	Арга хэмжээ 1. Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байна.	Сургалтын тоо	Ахлах түшмэлийн сургалтад хамрагдсан	1	1. Батлан хамгаалах яамнаас “Батлан хамгаалах үйл ажиллагааны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн шалгалт сургалт”-д 2025.05.22-ны өдөр хамрагдсан.	2025.05.22	
2.	Арга хэмжээ 2. Үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, дээд байгууллагаас гаргасан тогтоол, хуулийн шийдвэртэй цаг тухайд нь танилцсан байна.	Судалсан тоо	-	2	1.Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрийн албаны тусгай шалгалт өгөхөөр бэлтгэн холбогдох хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор Мерит сургалтын төвийн сургалтад хамрагдсан	2025.04.07- 2025.04.24	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын нэгдсэн төлөвлөлт,
хэрэгжилт хариуцсан ахлах
мэргэжилтэн



Б.Баярдулам

/2025.06.10/